Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

##### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6747.3 сая төгрөгөөр буюу 80.9 хувиар буурсан байна.

*Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	169,101.3	167,596.2	(1,505.1)
Авлага	253,874.0	167,768.3	(86,105.6)
Урьдчилгаа			-
Бараа материал	332,709.8	26,756.1	(305,953.7)
Үндсэн хөрөнгө	7,584,012.5	1,230,310.2	(6,353,702.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,339,697.6</b>	<b>1,592,430.8</b>	<b>(6,747,266.8)</b>
Өр төлбөр	40,057.9	8,749.7	(31,308.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,299,639.7	1,583,681.1	(6,715,958.6)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>8,339,697.6</b>	<b>1,592,430.8</b>	<b>(6,747,266.8)</b>

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Хүснэгтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэлтэй 1.5 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны давсан хэсгийн зарцуулалттай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 86.1 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага 3.1 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 40.8 сая, байгууллагаас авах авлага 16.5 сая, зээлийн авлага 25.7 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бараа материалын данс 305.9 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө данс 6353.7 сая төгрөгийн тус тус буурсан нь тайлант онд боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны оны эхний 31.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулж, оны эцэст Засаг даргын тамгын газрын 2.8 сая төгрөгийн, Орон нутаг хөгжүүлэх сангийн 4.9 сая төгрөгийн, эргэлтийн эмийн сангийн 1.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд -6,681.7 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 6,715.9 сая төгрөгөөр буурсан байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 167.6 сая төгрөг болж, өмнөх оноос 1.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>			-
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>			-
<b>Төгрөг</b>			-
Төрийн сангийн харилцах	169.00	167.50	(1.50)
Арилжааны банк дахь харилцах	0.07		(0.07)
Нэмэлт санхүүжилтийн харилцах		0.10	
<b>Гадаад валют</b>			-
Арилжааны банк дахь харилцах			-
Замд яваа мөнгөн хөрөнгө			-
<b>Дүн</b>	<b>169.07</b>	<b>167.60</b>	<b>(1.47)</b>

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ийн тайлан

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдлээс 1.0 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны давсан хэсгийн зарцуулалттай холбоотой байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 253.8 сая төгрөг болж, өмнөх оноос 86.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	3.10		(3.10)
Төлбөртэй үйлчилгээний авлага	40.80		(40.80)
Татаас, санхүүжилтийн авлага			-
Хувь хүмүүст олгосон зээл			-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/			-
Татаас, санхүүжилтийн авлага			-
Байгууллагаас авах авлага	16.50		(16.50)
Хувь хүмүүсээс авах авлага	193.40	167.80	(25.60)
<b>Дүн</b>	<b>253.80</b>	<b>167.80</b>	<b>(86.00)</b>

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ийн тайлан

Тайлант оны Хоршоо хөгжүүлэх сан 167.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан байна.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны өөрчлөлт гараагүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 26.7 сая төгрөг болж, өмнөх оноос 306.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

<i>/сая төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>Түүхий эд материал</b>			-
Тусгай зориулалттай материал	18.90		<b>(18.90)</b>
Эм боох материал	38.10	14.30	<b>(23.80)</b>
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>			-
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	7.10		<b>(7.10)</b>
<b>Хангамжийн материал</b>			-
Бичиг хэргийн материал	3.20		<b>(3.20)</b>
Аж ахуйн материал	89.30	10.50	<b>(78.80)</b>
Сэлбэг хэрэгсэл			-
Түлш, шатах тослох материал	6.10		<b>(6.10)</b>
Барилгын засварын материал	0.70		<b>(0.70)</b>
Хүнсний материал	71.50		<b>(71.50)</b>
Бусад хангамжийн материал	97.80	1.90	<b>(95.90)</b>
<b>Мал амьтад</b>			-
<b>Дүн</b>	<b>332.70</b>	<b>26.70</b>	<b>(306.00)</b>

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ийн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 95.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 114.7 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч 98.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 188.2 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд өөрчлөлт ороогүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,230.2 сая төгрөг болж, өмнөх оноос 6,353.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>7,479.90</b>	<b>1,223.30</b>	<b>(6,256.60)</b>
Барилга, байгууламж, орон сууц	6,602.30	854.70	(5,747.60)
Авто-тээврийн хэрэгсэл	72.90	27.90	(45.00)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	336.50	150.20	(186.30)
Тавилга, аж ахуйн эд хогшил	181.40	24.10	(157.30)
Зам, гүүрийн байгууламж	128.10	104.90	(23.20)
Бусад үндсэн хөрөнгө	81.10	61.10	(20.00)
Дуусаагүй барилга, байгууламж	77.60	0.40	(77.20)
Ном			-
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>104.12</b>	<b>6.90</b>	<b>(97.22)</b>
Программ хангамж	0.02		(0.02)
Бусад биет бус хөрөнгө	104.10	6.90	(97.20)
<b>Дүн</b>	<b>7,584.02</b>	<b>1,230.20</b>	<b>(6,353.82)</b>

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ийн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 19.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 138.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэгүй хүлээн авч, 7,160.7 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж данснаас хасжээ. Үндсэн хөрөнгөнд 141.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 8.7 сая төгрөг болж, өмнөх оноос 31.4 сая төгрөгөөр буурсан байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	17.10	2.80	(14.30)
Байгууллагад төлөх өглөг	16.40	5.90	(10.50)
Бараа үйлчилгээний бусад өглөг	6.60		(6.60)
<b>Дүн</b>	<b>40.10</b>	<b>8.70</b>	<b>(31.40)</b>

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ийн тайлан

Тайлант онд 387.7 сая төгрөгийн өглөг нэмэгдэж 419.0 сая төгрөгийн өглөг барагдаж, оны эцэст Орон нутгийн хөгжлийн сангийн 4.9 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сангийн 1.0 сая төгрөгийн, Засаг даргын тамгын газрын 2.8 сая төгрөгийн, нийт 8.7 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

**3.5.10 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 9,791.0 сая төгрөг болж, өмнөх оноос 9,016.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>1,903.00</b>	<b>452.60</b>	(1,450.40)
Өмч /төрийн/	1,903.00	452.60	(1,450.40)
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,639.00</b>	<b>887.30</b>	<b>(1,751.70)</b>
Өмнөх үеийн үр дүн	2,556.50	7,569.00	5,012.50
Тайлант үеийн үр дүн	82.50	(6,681.70)	(6,764.20)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,757.70	243.80	(3,513.90)
<b>Дүн</b>	<b>8,299.70</b>	<b>1,583.70</b>	<b>(6,716.00)</b>

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ийн тайлан

Тайлант онд -6,681.7 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан, боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлттэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц дансанд бууруулах, өмнөх үеийн үр дүн дансанд нэмэгдүүлэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт бичилт хийгдсэнтэй холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 6,681.7 сая төгрөгөөр буурсан байна

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,419.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,266.4 сая төгрөгийг урсгал зардалд, 153.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 964.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 237.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 115.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 103.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Алтай сум нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,313.9 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 1,048.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 237.6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 27.5 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөгийн төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс 66.2 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, үндсэн үйл ажиллагааны орлого /хоршоо хөгжүүлэх сан/ 87.5 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 105.9 сая төгрөг буюу 92.5 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

#### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 27.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүний 27.5 сая төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 51 дугаар тогтоолоор Алтай сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 436.0 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 95 дугаар тодотголоор 480.1 сая төгрөгөөр буюу 44.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 46 дүгээр хуралдааны тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг 480.1 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 519.9 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 39.7 сая төгрөгөөр буюу 8.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### **Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+/ бүүралт /-/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	475,005.1	510,383.3	35,378.2	98.2
II.Татварын бус орлого	5,150.0	9,524.5	4,374.5	1.8
<b>Нийт дүн</b>	<b>480,155.1</b>	<b>519,907.8</b>	<b>39,752.7</b>	<b>100</b>

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 65.5 сая, хөрөнгийн орлогын албан татвар 17.6 сая, бууны албан татвар 0.7 сая төгрөгөөр, газрын төлбөр 11.8 сая, хог хаягдлын хураамж 7.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орон нутгийн орлого төлөвлөгөөний давж биелэгдэхэд цалин хөлсний орлогоос 191.1 сая, хөрөнгө борлуулсны орлогоос 5.3 сая, улсын тэмдэгтийн хураамж 49.8 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамжаас 7.3 сая, малын татвараас 9.5 сая, ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрөөс 1.6 сая, агнуурын нөөцийн төлбөрөөс 222.9 сая, хүү торгуулийн орлого 9.4 сая төгрөг орсон нь орлого давж биелэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 103.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 510.4 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 18.4 сая төгрөгийн санхүүжилтийн төвлөрч, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 59.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

#### **Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар: /сая төгрөг/**

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	76,651.90	72,651.90	4,000.00
2	Сумын ЗДТГ	542,036.50	532,352.90	9,683.60
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	286,548.50	283,715.10	2,833.40
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	28,536.50	27,998.60	537.90
5	Хүүхдийн 1-р цэцэрлэг	87,250.70	86,062.80	1,187.90

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	Соёлын төв	42,023.70	41,892.80	130.90
9	Эрүүл мэндийн төв	32,867.50	32,867.50	0.00
10	ОНХСан	208,948.90	208,948.90	0.00
11	СХС	115,000.00	27,468.90	87,531.10
<b>Нийт дүн</b>		<b>1,419,864.20</b>	<b>1,313,959.40</b>	<b>105,904.80</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 8.0 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 14.2 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 6.9 сая төгрөгийн нийт 29.1 сая нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 11.6 сая, томилолтын зардалд 0.5 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 17.1 сая төгрөгийн нийтдээ 29.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дүгээр сарын 02-ны өдрийн 46 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,207.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 61.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд дараах зардлуудыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: цалин хөлсний зардлыг 4.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 127.8 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 10.0 сая төгрөгөөр, зарим төрлийн зардлыг 6.7 сая, нийт 149.2 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Тайлант онд шилэн дансны хэрэгжилтийг тус аудитын газраас 2022 оны 1-9 сарын хэрэгжилтийг шалгасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн албаны зөвлөлийн 2019.07.16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах, зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					-
Албан шаардлага					
Зөвлөмж	1	0	1	0	100.00
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.00</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газарт “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 338.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 86.7 сая төгрөгийн залруулга хийгдэж, 1.1 сая төгрөгийн акт тогтоож, 68.2 сая төгрөгийн албан шаардлага, 182.1 сая төгрөгийн зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын ИТХ	4	23,229.40	2	15,839.40	1	260.00	1	7,130.00		
2	Сумын ЗДТГ	5	314,918.80	2	70,893.00	1	850.00	1	61,095.20	1	182,080.60
8	ОНХСан	-	-								
9	СХС	-	-								
	<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>338,148.20</b>	<b>4</b>	<b>86,732.40</b>	<b>2</b>	<b>1,110.00</b>	<b>2</b>	<b>68,225.20</b>	<b>1</b>	<b>182,080.60</b>

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

### 1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								